

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 1 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2015 оны нэгдүгээр сарын 8-ны 10 цаг 11 минутад эхэлж, 12 цаг 15 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн даргын өрөөнд болж, нийт 2 цаг 04 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Сайхан-Овоо сумын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцээд Сайхан-Овоо сумын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад ...Амаржаргал 76,63 оноогоор тэнцэж, уг ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тул тухайн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэхийг дэижсэн тогтоол гаргахаар шийдвэрлэв.
2	Эрүүл мэндийн газрын Эдийн засаг, удирдлага мэдээллийн хэлтсийн дарга, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргад сонгон шалгаруулсан П.Оюунчимэг, Д.Нямтогтох нарт дүгнэлт гаргах тухай	Эрүүл мэндийн газраас Эдийн засаг, удирдлага мэдээллийн хэлтсийн дарга, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргад сонгон шалгаруулж ирүүлсэн П.Оюунчимэг, Д.Нямтогтох нарт дүгнэлт гаргах тухай асуудлыг хэлэлцээд тухайн ажлын байрны шаардлагыг өөрчлөх, сонгон шалгаруулалтыг дахин хийх талаар санал, зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.
3	Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчийн албан тушаалд нэр дэвшсэн Э.Бадамсүрэнгийн өргөдлийн тухай	Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчийн албан тушаалд нэр дэвшсэн Э.Бадамсүрэнгийн өргөдлийг хэлэлцээд Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцөд үлдээхээр шийдвэрлэв.
7	Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байгаад ажлаас халагдсантай холбогдолтой гомдлыг хянан шийдвэрлэх тухай	Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байгаад ажлаас халагдсантай холбогдолтой гомдлыг хянан шийдвэрлэх комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар шийдвэрлэв.
5	Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сул орон тооны захиалгыг нөөцийн зард зарлуулах тухай.	Нутгийн захиргааны 8 байгууллагаас иршлсэн захиалгын дагуу дэс түшмэлийн 8, туслах түшмэлийн 4 нийт 12 сул ажлын байрыг төрийн жинхэнэ албаны нөөцөөс нөхөх зард зарлуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.
6	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Дэлгэрхангай сум хариуцсан мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Дэлгэрхангай сум хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд 68,33 оноо авч, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 196 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Дэлгэр овогтой Оюунбилэгийг томилуулахаар нэр дэвшүүлэв.
7	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч томилох тухай	Хууль зүйн хэлтсийн дарга Б.Түвшинбаярыг Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгчийн үүрэгт ажлаас нь 2016 оны 01 дугаар сарын 08-ны өдрөөс чөлөөлж, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Л.Ганбатыг мөн өдрөөс эхлэн сонгон шалгаруулалтад тэнцсэн хүн томилогдох хүртэл хугацаанд тус зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгчээр томилов